



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/662

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож,
захиалагчийн төлөөлөгч томилж,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны “Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” А/261 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ХӨАХААГ/20240102177 дугаартай Хивэг 3 дугаар багцыг нийлүүлэхээр 62,964.000 (Жаран хоёр сая есөн зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Дайчин Монгол” ХХК -ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Дайчин Монгол” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах дүгнэх, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-г томилж, ажил, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийн ахлагч:

Я.Эрхэмбаяр

(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан
ахлах мэргэжилтэн)

С.Анхбаяр

(Аймгийн Мал хамгаалах сангийн нярав,
менежер)

Э.Балдорж

(“Дайчин Монгол” ХХК-ийн захирал)

Э.Анхцэцэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
нягтлан бодогч)

Т.Хулгана

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
нийтлэг үйлчилгээний дарга)

6712012048

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Т.Пүрэвхүү

(Аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газрын
малын бэлчээр, тэжээл усан хангамжийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Мал хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх Хивэг 3 дугаар багцыг нийлүүлэхээр гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийн ахлагч (Я.Эрхэмбаяр)-д, захиалагч, тендерт оролцогчийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ТӨМӨРБААТАР